

АКИО ТАКАХАРА



Акио Такахара нь Токиогийн Их Сургуулийн Хууль зүй, улс төрийн дээд сургуулийн орчин үеийн Хятадын улс төр судлалын профессор юм. Тэрээр 1988 онд Сассексийн их сургуульд докторын зэрэг хамгаалсан. Сүүлд Хонг Конг дахь Японы улсын Ерөнхий консулын газар, Бээжин дэх Японы Улсын Элчин сайдын яам, Харвардын их сургууль, Бээжингийн их сургууль, Хятад судлалын Меркатор институт, Австралийн үндэсний их сургуульд зочин багшаар ажиллаж байсан. Токиогийн их сургуульд ажиллахын өмнө Ж.Ф.Оберлиний их сургууль, Риккёогийн их сургуульд багшилж байв. Тэрээр Японы Ази судлалын нийгэмлэгийн ерөнхийлөгч, XXI зууны Шинэ Япон-Хятадын найрамдлын хорооны ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байсан. Акио нь 2018-2020 онд Токиогийн Их Сургуулийн Төрийн бодлогын дээд сургуулийн декан, 2020-2023 онд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) Огата Садакогийн энх тайван, хөгжлийн судалгааны хүрээлэнгийн захирлаар тус тус ажилласан. Тэрээр одоо Японы Олон улсын харилцааны хүрээлэнгийн орон тооны бус ахлах судлаач, Японы олон улсын харилцааны форумын хүндэт судлаач, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) Огата Садакогийн Энх тайван, хөгжлийн судалгааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах зөвлөхөөр ажиллаж байна. Такахара нь англи хэл дээр *"Хувьсгалын дараах Хятадын цалингийн бодлого"*, (Макмиллан, 1992), *Орчин үеийн эриний Япон-Хятадын харилцаа*, (хамтран зохиогч болсон, Рутлеж, 2017), *"Азийн орнууд ба Хятад улсын хоёр талын харилцааны харьцуулсан судалгааны тусгай дугаарын танилцуулга"*, *Орчин үеийн Зүүн Ази судлалын сэтгүүл*, Боть 10, дугаар 2 (2021) нийтлэлүүдийг хэвлүүлжээ.

Лекцийн тухай товч мэдээлэл

Хятадын дипломат харилцаанд сүүлийн үед ямар өөрчлөлт гарч байна вэ, энэ өөрчлөлт нь дотоод бодлоготой хэрхэн уялддаг вэ? Такахара эхлээд Хятадын Оростой холбоотой бодлого, Украины дайнд баримталж буй байр сууринд анхаарлаа хандуулж, Хятадаас АНУ болон Европын талаар баримталж буй бодлоготой уялдуулан, тэдгээр бодлогыг хэрхэн бүрдүүлж, хөгжүүлсэн талаар ярих болно. "Тэг Ковид" бодлогоор улам даамжирч, энэ бодлогыг цуцалснаар ч сэргэхгүй байгаа Хятадын эдийн засгийн уналт нь ялангуяа Хятадын Европт хандах хандлага, Японд чиглэсэн тогтвортой бус харилцааны байдал зэрэгт нөлөөлсөн. Эдийн засгийн энэхүү удаашрал нь нийгэм, улс төрийн тогтворгүй байдалд нөлөөлбөл яах вэ? Энэ нь удирдлагыг өөр тийш нь чиглүүлэх дипломат бодлого, эсвэл бүр Тайван уруу довтолоход хүргэх болов уу? Эдгээр асуултыг зохих ёсоор өгч, оролцогчидтой цааш хэлэлцүүлэхээр урьдчилсан дүгнэлтийг гаргах болно.